

Гарчиг

1. Төслийн товч танилцуулга
2. Төслийн гол ба болзошгүй нөлөөлөл
3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний зорилт
 - 3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
 - 3.2 Хог хаягдлын төлөвлөгөөний биелэлт
 - 3.3 Техникийн нөхөн сэргээлтийн ажлын биелэлтийн тайлан
 - 3.4 2023 оны нэгдсэн төсвийн биелэлт
4. Дүгнэлт

Төслийн товч танилцуулга

Төслийн товч тодорхойлолт

“Цохио толгой 2” шохойн чулууны ордын талбай нь засаг захиргааны нэгжийн хувьд Дархан – Уул аймгийн Хонгор сумын нутагт Улаанбаатар хотоос 220 орчим км-т, Дархан – Уул аймгаас зүүн урд зүгт 10км-т, Хонгор сумаас зүүн хойш 20 орчим км зайд МҮ – 004658 дугаар бүхий тусгай зөвшөөрлийн талбайд оршино. М-48-93 нэрлэбэрт байрлана.

Хүснэгт 1. Талбайн солбицол

Д/д	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	106	02	22	49	26	05
2	106	02	22	49	26	20
3	106	02	55	49	06	20
4	106	02	55	49	06	05



Төслийн зорилго

Орд газраас шохойн чулууг олборлон хямд, сайн чанарын шохойн чулууг шохойн болон цементийн үйлдвэрүүдэд нийлүүлэх, орон нутагт тодорхой хэмжээний ажлын байр бий болгох, цаашид ордыг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр байгуулах замаар ашиглалтыг нь сайжруулан ордоос олборлосон бүхнийг нэмүү өртөг шингэсэн

бүтээгдэхүүн болгож борлуулах, орд орчмын унаган төрхийг эргүүлэн сэргээх нөхөн сэргээлт хийхэд голлон анхаарах зорилт тавин ажиллаж байна.

Байгаль орчны төлөв байдлын суурь нөхцөл

Уул зүй: Шохойн чулууны ордын талбай нь Хэнтийн уулархаг мужын баруун хойд салбар уулсуудын хүрээнд Хараа голын районд багтдаг. Газарзүйн байршлын хувьд Хэнтийн нурууны баруун хойд хэсгийн дунд зэргийн уулархаг мужид хамаарагдах бөгөөд хамгийн өндөр цэг нь Их Нарст уул /1419.2м/, хамгийн нам цэг нь Дархан хотын онгоцны буудал /710м/ юм. Дундаж харьцангуй өндөр нь 300 – 400м. Нийт нутаг нь өвс ургамлаар бүрэн бүрхэгдсэн, чулуулгийн гарш илэрц муу, харин уулын өмнөд хажуунууд чулуулгийн гарш илэрц сайтай, заримдаа бага хэмжээний нуранга, хад цохиотой байдаг.

Ус зүй: Талбайн хэмжээнд усан сүлжээ нилээд сайн хөгжсөн ба хамгийн том гол нь Хараа гол юм. Хараа голын усны өргөн 3 – 6м, гүн нь 1м – ээс хэтэрдэггүй. Талбайн төв хэсгээр нь Мухар, Хүйтний голууд урсдаг.

Уур амьсгал: Тус нутаг нь өвөлдөө бага зэргийн цастай хүйтэн, зундаа бороотой халуун байх ба эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын жилийн дундаж хэм -19°C-д хүрэх бөгөөд хамгийн хүйтэн 1-р сард -37°C болж, хамгийн дулаан нь 7-р сард 35°C-д хүрнэ. Жилд унах хур тунадас дунджаар 244мм байдаг. Цас 10 – р сараас эхлэн 3 – р сар дуустал орох баг цасан бүрхүүлийн дундаж зузаан 0.5м хүрнэ. Салхины чиглэл хойд талаасаа зонхилох ба дундажаар 3.5м/сек хурдтай боловч, 5-р сард 20-24м/сек хүртэл шороон шуурга болдог.

Хөрс, ургамал: Нийт нутаг нь хөрс ургамлаар өтгөн хучигдсан бөгөөд Шарын голын зүүн талын хэсэг нь өтгөн нарсан болон хусан ойгоор хучигдсан, олон төрлийн цэцэгт ба өвслөг ургамлаар бүрэн бүрхэгдсэн, уулын ар хажууд нарс, хусан ой, багаар улиангар голын хөндийд бургас ховроор хус, нарс, улиас зэрэг шилүүст ба навчит модлог ургамал байдаг.

Амьтан: Ан амьтадаас, хярс, дорго, тарвага, жигүүртэн амьтадаас тоодог, тогруу, ятуу, хүтүү амьдардаг бөгөөд гол горхины усанд загас, жараахай элбэг тохиолдоно.

Хүн ам, эдийн засаг: Судалгааны талбайн хүн ам нь газар тариалан мал аж ахуй эрхэлдэг, олон ястан үндэстний нутаг юм. Орд нь Дархан, Сэлэнгэ аймгийн Сайхан сумтай шороон замаар холбогдсон бөгөөд Дархан-Эрдэнэтийн чиглэлийн хатуу хучилттай замаас баруун зүгт 3км зайд оршдог. Талбайн хэмжээнд орших томоохон суурин газар нь Дархан хот бөгөөд 200 гаруй км урт төмөр замаар, 220 гаруй км урт засмал замаар Улаанбаатар хотоос холбогдоно. Эдгээр суурийн газруудад нүүрс олборлох уурхай, алт олборлох уурхай, ой модны аж ахуй, ахуй үйлчилгээний ба

харилцаа холбооны салбар, эмнэлэг, 10-н жилийн дунд сургууль зэрэг үйлдвэр, үйлчилгээ, ахуйн соёлын төвүүд оршино. Нутгийн аль ч хэсэгт жилийн дөрвөн улиралд автомашинаар явах бүрэн бололцоотой.

Төслийн гол ба болзошгүй нөлөөлөл

Агаар мандал

Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэл хэм хэмжээ MNS6063:20108, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS4585:2007

Сөрөг нөлөөлөл:

- Хөрс хуулалт, дайрга үйлдвэрлэлт, тээвэрлэлтийн үед тоос босч агаарыг бохирдуулж болзошгүй.
- Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчныг хэсэгчилсэн бохирдолтыг бий болгоно.
- Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтэцтэй холбоотойгоор газар овоолгод дарагдах зэргээр эвдрэлд орно.

Ус, усан орчин

Усны тухай хууль, Хаягдал бохир ус MNS4943:2008, Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага, Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам.

Сөрөг нөлөөлөл:

- Түлш шатахуун, тослох материалууд бохир ус, химийн янз бүрийн бодисууд алдагдах, асгарах зэргээс үүдэн бага гүнд орших уст давхарга болон гадаргын усыг бохирдуулж болзошгүй.
- Ахуйн шингэн болон хатуу хог хаягдалаа зөв менежмент явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус бактер болон химийн бохирдолд орж болзошгүй.

Хөрс, ургамал, газар

Газрын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Ойн тухай хууль, Ой хээрийн түймрээс хамгаалах тухай, Ургамал хамгааллын тухай, Байгаль орчин, Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, нэр томъёо, тодорхойлолт MNS5914:2008, Байгаль орчин, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS5915:2008, Байгаль орчин, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS5916:2008, Байгаль орчин, Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн

сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS5917:2008, Байгаль орчин, эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага MNS5918:2008.

Сөрөг нөлөөлөл:

- Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтэцтэй холбоотойгоор газар овоолгод дарагдах зэргээр эвдрэлд орно.
- Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэхь тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох.
- Уурхайн малтмалт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсч тоосжилт үүсгэх.
- Орд орчмын байгалийн гадаад үзэмж муудаж болзошгүй.
- Газрын гадарга хөрс ахуйн хаягдал шатахуун, тослох материалаар бохирдож болзошгүй.

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжиж орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

2023 оны Уулын ажлын тайлан

“Цохио толгой 2” шохойн чулууны уурхай нь 2023 онд 2022 оны уулын ажлыг цааш үргэлжлүүлэн явуулсан. Ингэхдээ уурхай 40м гүнд буюу +765м-ийн түвшин хүртэл, давхаргын суналд хөндлөн чиглэлээр уулын ажлыг явуулсан. Энэ үед уурхайн урт 285м, өргөн дунджаар 155м, уурхай 4 га талбайг эзэлж байна. “Цохио толгой 2” ордоос 2023 онд 22.5мян.м³ хөрс хуулж, 18.0мян.тн шохойн чулуу, 19.8мян.м³ дайрга олборлон борлуулсан байна.

Уурхайн ажиллах горим. “Цохиот толгой – 2” уурхайн 2023 онд гүйцэтгэх уулын ажлын хэмжээг үндэслэн жилийн турш тасралтгүй ажиллана. Уурхайн ажлын горимыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хөрс хуулалтын ажил. Цохио толгой – 2 уурхайн үндсэн хөрсний чулуулгийн хатуулаг нь VIII-X зэрэглэлд хамаарагдаж байгаа нь хөрсний чулуулгийг авахдаа урьдчилан өрөмдлөг-тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлт хийж шилжүүлэх шаардлагатай. Хөрсний чулуулгийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлсний дараа эксковатороор автосамосвалд ачин ил уурхайн гадна байрлах гадаад овоолгын талбайд байрлуулж, хөрс хуулалтын ажилд 1.2 м³-ын утгуурын багтаамжтай урвуу утгуурт гидравлик эксковатораар ажлыг хийж гүйцэтгэлээ.

Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 2. Уурхайн 2023 онд хуулсан хөрсний тооцоо

№	Үзүүлэлтүүд		2023 онд ажиллах улирал				Нийт
			I-р улирал	II-р улирал	III-р улирал	IV-р улирал	
1	Уулын цул	мян.м ³	7.9	7.9	7.9	5.7	29.4
2	Хөрс хуулалт	мян.м ³	6.00	6.0	6.0	4.5	22.50
		мян.тн	13.2	13.2	13.2	9.9	49.5
3	Шохойн чулуу олборлолт	мян.м ³	1.9	1.9	1.9	1.2	6.92
		мян.тн	5	5	5	3	18.0
4	Хөрс хуулалтын коэффициент	м ³ /м ³	6.86	6.86	6.86	8.58	7.15
		м ³ /тн	2.64	2.64	2.64	3.30	2.75

Өрөмдлөг-Тэсэлгээний

“Монмаг” ХХК –тай гэрээгээр хамтран ажиллаж тэсэлгээний ажлыг улиралд 1 удаа гэхээр жилд 4 удаа төлөвлөгөөний дагуу хийхээс 4 удаа хийгдсэн. Өрөмдлөг тэсэлгээний тооцоо энэ онд 62.7мян.м төлөвлөснөөс 44.7мян.м³ уулын цул тэсэлж, нийт 5787.9 тууш метр өрөмдлөг хийж, 28.6тн бодис хэрэглэсэн байна.

Хөрс, тээвэрлэлт:

Дөрөвдөгчийн хурдсыг эксковатораар шууд утган автосамосвалд ачиж үржил шимт хөрсний овоолгын талбайд тээвэрлэж, үндсэн чулуулгийг өрөмдлөг тэсэлгээний аргаар урьдчилан сийрэгжүүлсний дараа гадаад овоолгын талбайд шилжүүлсэн. Хөрсний тээврийн зай дунджаар 400 м ба дөрөвдөгч хурдаснаас үржил шимт хөрсийг хуулан уурхайн зүүн талд байрлах хуучин шимт хөрсний овоолго дээр нэмж 4.2 мян.м³ –ийг нэмж овоолго хийгдэх байсныг уурхайн урд тавигдаж байгаа Автозамын замын ажилд өгсөн.

Шохойн чулуу тээвэрлэлт:

Шохойн чулууг мөн өрөмдлөг тэсэлгээний аргаар урьдчилэн сийрэгжүүлсний дараа шохойн чулууг түр овоолго руу 400м зайд Nowo маркийн автосамосвал ашиглан

тээвэрлэж бутлуурт өгдөг. Бутлуураас гарсан шохойн түүхий эд болох буталсан шохойн чулууг агуулах руу тээвэрлэдэг.

Байгаль орчны менежмент

Ордыг ил уурхайгаар ашиглах нөхцөлд ил уурхай, гадаад овоолго, үйлдвэрийн барилга байгууламж автозам, уурхайн тосгон зэрэгт зориулсан 8 га эдэлбэр газар, талбайн гадаргуу өртөгдөж байна. Үүний 7.8 га талбай нь 2022 оны эцэст эвдрэлд орсон байсан бөгөөд энэ онд нэмж 0.2 га талбай уулын ажилд өртөж байгаа.

Эдэлбэр газруудыг зөв ашиглан байгаль орчныг унаган төрхөөр нь хадгалан хамгаалах ажлыг уурхай барьж байгуулсан цагаас эхлэн байгаль орчныг хамгаалах болон эвдэрсэн газрыг нөхөн сэргээх зорилгыг жил бүрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган батлуулж гүйцэтгэлийг дүгнүүлж явдаг. Байгаль орчиноо хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд байгууллагын ажилчдад 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Мөн орон нутгийн оролцоог идэвхижүүлэх ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагын ажилтнуудаас заавар зөвлөгөөг авч ажиллаа. 2023 онд 6 чиглэлээр ажлуудыг хийхээр төлөвлөсөн.

Төлөвлөгөөнд тусгасан ажлуудын биелэлтийн тайлан

1. Шатах, тослох материалаар хөрс бохирдуулах, олон салаа зам гаргахаас сэргийлэж уурхайн урдуур гарсан шороон замыг сайжруулан засч, үйлдвэрийн доторх тээврийн хэрэгсэлийн зогсоол хийж, автозам болон уурхайн ажлын тавцан мөргөцөгийн тоос, шороог багасгах зорилгоор усны машинаар гаднах орчинд услагааг тогтмол хийж байна.






2. Ажилчдын хотхонд хатуу хог хаягдлын нэгдсэн цэгтэй болж, ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж ахуйн хог хаягдлаа Дархан – Уул аймгийн “Дархан хот Төхижилт үйлчилгээний газар”-тай гэрээ хийж хамтран ажиллаж байна.

3. Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж ахуйн шингэн хаягдлаа ялган хаяж тусгай цооногт төвлөрүүлэн бохир ус соруулан зайлуулах “Марз Зүрх Хайрхан” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн уурхайн засварын цехээс гарсан ашигласан тос маслыг эргэх зуухны булны тосолгоонд хэрэглэсэн. Зуны улиралд гал тогоо, ажилчдын байр, орчин тойрны хогийн саванд хортон шавьж, халдваргүйжүүлэлтийн ариутгалыг хийлгэж, ариутгах микробиологийн бэлдмэлээр уусмал бэлтгэн 08, 09, 10-р саруудад ахуйн орчинд цацсан.

Хатуу болон, хортой хог хаягдлыг цуглуулах хогийн савыг өөрсдийн нөөц бололцоогоор барьж ашиглалтанд оруулаад байна. Хатуу хог хаягдлыг Дархан Уул аймгийн хот тохижилтын газартай гэрээ байгуулан, гэрээний дагуу сард 1 удаа хогийн цэгрүү ачуулж байна. Мөн Үлэмж хүдэр ХХК-тай аюултай хог хаягдлыг нийлүүлэх гэрээ байгуулан аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдлын дагалдах хуудсын дагуу 12сард нэг удаа хүлээлгэн өгхөөр ажиллаж байна.



4. Уурхайн ашиглалтын үед гал гарч болзошгүй, тамхины цэг зэрэг хэсгүүдэд галын самбар байрлуулж, ил гал гаргах, тамхи татахыг хориглосон санамжуудыг тавих, тэмдэг тэмдэглэгээ хаалт хашлагыг сайжруулан засаж сэлбэсэн.



5. 2023 онд ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа болон ажилчдыг идэвхижүүлэх, байгууллагын дотоод зохион байгуулалтыг сайжруулах чиглэлүүдээр сургалтуудыг Дархан Уул аймгийн Цээнэ эмнэлэг, Ойгон нөмрөн ТББ, Оргил эрдэм ундрах ХХК зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.







6. Уурхайд тоос шороо босохоос сэргийлэх мөн эрүүл ахуйн таатай орчин бүрдүүлэх, ногоон байгууламж үүсгэх зорилгоор 2023 онд уурхайн засварын хэсгийн ойр орчмын 0.4 га талбайд усалгааг тогтмол хийсэн, ногоон байгууламж мод бутыг тогтмол усалгаа хийж, шинээр мод суулгасан талбайг хамгаалж хашаа татаж ургуулсан, уурхай орчмын анхааруулах хаяг самбаруудыг сэргээж байрлуулсан. Мөн энэ оны хавар, намрын улиралд 5 төрлийн мод тарьсан үүнд: хайлаас-200, агч-100, чяцаргана-20, монгол сакура-3, монос-20 нийт 343 ширхэг шинэ мод тарьсан байна.









7. Уурхайн эзэмшлийн газар нутагт нийт төлөвлөсний дагуу 1га газарт биологийн нөхөн сэргээлт, 0.5га газарт техникийн нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгөв









Бусад ажил

Нийгмийн хариуцлагын хүрээнд Хонгор сумын ЗДТГазарт Онгой байдлын газраас зохион байгуулагдсан сумыг нүүлгэн шилжүүлэх хөдөлгөөнд 10.000.000 /арван сая/ төгрөгийн өртөгтэй 2 ширхэг асар авч өгсөн. Шинэ жил, цагаан сарын баяруудад хүүхэд ахмад настнуудад хүндэтгэл үзүүлсэн.

Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Уулын ажлын хөрс хуулалт, элс олборлолт, тээвэрлэлтийн үед 24,1тн тоосжилт үүсэж агаарыг бохирдуулахаар тооцоо гарсан. Дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгох бөгөөд энэ жил нийт 15,03 тн хорт бодис ялгаруулахаар байна.

2023 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигласан техникүүд:

1. Өрөм СБУ-100 1ш
2. Самосвал Хово-336 1ш
3. Эксковатор LS-290-7 1ш
4. Авто ачигч ХГМА-951 1ш
5. Авто ачигч ZL-935 1ш

Дээрх тоног төхөөрөмж ажиллуулахад цагт 126 буюу нэг ээлжиндээ 1008л дизелийн түлш хэрэглэнэ. 2023 онд- ялгаруулах нийт хорт хийн хэмжээ нь 23.2 тн байна.

Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Унд ахуйн усан хангамжинд нийт 980 м³ ус хэрэглэхээр 2023 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгасан.

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлийг бууруулж хэрэглэсэн тос маслыг Эргэх зуухын тосолгоонд хэрэглэж хаягдалгүй болгож шийдвэрлэсэн.

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

2023 оны уулын ажлаар нийт 0.5 га талбай олборлолтонд өртөж. Ордын уул геологийн тогтоцоос хамааран дотоод овоолго хийх боломжгүй тул гадаад овоолготой, тээвэртэй ашиглалтын системээр уулын ажлыг явуулж байна.

Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтцийн үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно.

Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэхь тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасана.

Уурхайн малталт, дотоод замууд, барилгын ажлууд зэрэг үйл ажиллагаанаас гарах сийрэг бүтэцтэй хөрс салхинд амархан хийсч тоосжилт үүсгэх

Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт:

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

арга хэмжээний хүрээнд:

а . Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэл Самосвал Хово, Эксковатор LS-290-7, Авто ачигч XGMA-951, Авто ачигч ZL-935 техникүүдийн 250мөт/цаг тутамд тос масло, маслын шүүрийг тухай бүр сольсон.

б . Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг тогтмол услаж төсөвлөсөн 1.492.560 төгрөг зарцууллаа.

в . Уулын ажилд хамрагдах 5 тээврийн хэрэгслийн агаарын бохирдлын төлбөрийг цаг тухайд төлсөн.

Хог хаягдлын менежмент.

Бохир усны хаягдлыг “Марз Зүрх Хайрхан” ХХК-тай гэрээ байгуулан сар бүр соруулж бохир усны нэгдсэн төв шугамд хаядаг, хатуу хог хаяглыг ангилж цуглуулан Дархан Уул аймгийн Дархан хотын тохижилт үйлчилгээний газартай гэрээ байгуулан хамтарч ажиллаж байна.

Нөхөн сэргээлтийн биелэлт

2023 онд манай компани техникийн нөхөн сэргээлтийг 0.5га-д, биологийн нөхөн сэргээлтийг 1 га талбайд тус тус хийсэн. Биологийн нөхөн сэргээлтийн 1 га талбайд 100 ширхэг улиас мод, 200 ширхэг хайлаас, 3 ширхэг Монгол сакура , 20 ширхэг монос, 20 ширхэг чацарганы мод шинээр тариалсан байна. Нийт зардалд 2.510.000 төгрөг зарцуулсан.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний биелэлт

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрч олон жил орхигдсон 8000 га талбайг нөхөн сэргээнэ гэж заасан байдаг. Энэхүү зорилтын хэрэгжилтийг хангах хүрээнд “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээнд нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон газрын тооллогыг зохион байгуулж 2023 онд Дархан-Уул аймгийн хэмжээнд уул уурхайн олборлолтын улмаас эвдэрч, нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон газрын тооллогын ажил явагдсан.

Дархан-Уул аймгийн 4 сумын 157 эвдэрсэн газрын нийт 1408,9 га талбайн зураг видеогоор баталгаажуулан бүртгэсэн. Үүнд: Дархан сумын 80.54 га, Орхон сумын 116.69 га, Шарын гол сум 602.8 га, Хонгор сум 608.9 га нийт лицензтэй талбайн 595.94 га, лицензгүй талбайн эвдрэл 812.9 га газрын судалгааг гаргаж эвдэрсэн газрын мэдээллийн санд оруулсан.

Дархан-Уул аймгийн БОАЖГ-ын 2023 оны 10-р сарын 09-ны өдрийн албан бичгийн албан даалгаврын хүрээнд Хонгор сумын 2-р баг Талын толгойн зам дагуу байрлалтай 1 га эвсрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлыг 11 дүгээр сарын 12-ны өдөр гүйцэтгэлээ.

2023 онд бид байгалийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийлээ:

1. Дархан-Уул аймгийн Хонгор сумын 2р баг Талын толгойн зам дагуу байрлалтай 49°23'24.7", 105°56'37.0 бүхий байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр эвдрэлд өртсөн 1га газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн.

2. Дархан-Уул аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас Хонгор сумын нутагт 25 толгой Монгол тарвагыг “Амьтны эрх хамгаалах нийгэмлэг” мэргэжлийн байгууллагатай хамтран нутагшуулах ажлыг 2023 оны 07 дугаар сарын 04-ны өдөр зохион байгуулж манай байгууллагын зүгээс 6.420.000 төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.

Хонгор сумын 2-р баг Талын толгойн зам дагуу байрлалтай эвдэрсэн газрыг нөхөн сэргээлт хийх 1 га газрыг Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/138 дугаар тушаалын “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал” -ын дагуу нөхөн сэргээх ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 12 -ний өдөр гүйцэтгэлээ.

Техникийн нөхөн сэргээлтийг авто ачигчаар хийж гүйцэтгэсэн. Ажлын арга нь авто ачигчаар түрж дүүргэлт хийж огцом үүссэн далан хэсгийг буулгаж хогтой хэсгийг дарж өндөр ирмэгийг дарсан.

Нөхөн сэргээлтийг 2 ээлжний авто ачигч , ИТА-1 нийт 3 хүний бүрэлдэхүүнтэй нэг авто ачигчаар гүйцэтгэсэн .



1. Орхигдож эвдэрсэн газрын зураг /нөхөн сэргээлт хийхээс өмнөх зураг/



Нөхөн сэргээлт хийж байх үеийн зураг



Нөхөн сэргээлт хийсний дараах зураг



2.Тарвага үржүүлгэ хийв

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН НУТАГТ ТАРВАГА СЭРГЭЭН НУТАГШУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2023.07.04

Дархан-Уул аймаг

Байгаль орчин аялал жуулчлалын газар нь Хонгор сумын нутагт 25 толгой Монгол тарвагыг "Амьтны эрх хамгаалах нийгэмлэг" мэргэжлийн байгууллагатай хамтран нутагшуулах ажлыг 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж хамгаалалтыг нутгийн иргэд, нөхөрлөл, байгаль хамгаалагчид хариуцууллаа. 25 толгой Тарвагыг 2 байршилд 2-3 толгойгоор бүл болгон 10 дошинд /нүх/ байршуулан дош тус бүр дээр газар зүйн солбицол цэг авч тэмдэглэл хөтөлж ажилласан.

Тарвага нутагшуулснаар тус бүс нутгийн биологийн төрөл зүйл нэмэгдэж, экологийн тэнцвэрт байдал бий болдог. Мөн Тарвага нь газрын хөрсийг сийрэгжүүлэх, ургамлын гарцыг нэмэгдүүлэх, цөлжилтийг саармагжуулах зэрэг олон талын ач холбогдолтой амьтан юм.

Тарвага нутагшуулах ажлын нийт зардал 16.500.000 төгрөг үүнээс байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд тусгагдсан 10.080000 төгрөг, Хонгор сумын “Идэр хайрхан” ХХК-нь байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 6.420.000 төгрөгийг дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.



ЗАХИАЛАГЧ:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН БОАЖГ-ЫН
ДАРГА Г. БАТБАЯР

ГҮЙЦЭТГЭГЧ:
“АМЬТНЫ ЭРХ ХАМГААЛАХ НИЙГЭМЛЭГ”
МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАХИРАЛ
БО-НЫ ГАВЬЯТ АЖИЛТАН
..... С. ДАМДИНСҮРЭН

**ДАРХАН УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМАНД “МОНГОЛ ТАРВАГА СЭРГЭЭН
НУТАГШУУЛАХ” АЖЛЫН ГЭРЭЭ**

2023 оны 06 сарын 19-ний өдөр Дугаар 2023/04

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Амьтны тухай” болон бусад хууль тогтоомжийг үндэслэн Дархан-Уул аймгийн Хонгор сумын 2 дугаар багийн нутаг Могойн гол, Их овоо гэх газар 25 толгой Монгол тарвага /marmot sibirica/ сэргээн нутагшуулах ажил /цаашид “ажил” гэх/ хийхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний зорилго, ач холбогдол оршино.

ХОЁР. ГЭРЭЭ БАЙГУУЛАГЧ ТАЛУУД

2.1 Нэг талаас Дархан-Уул аймгийн Хонгор сумын 2-р баг Могойн гол, Их овоо гэх газар /цаашид “Захиалагч” гэх/ нөгөө талаас Дархан-Уул аймгийн БОАЖГ, “Амьтны эрх хамгаалах нийгэмлэг” /цаашид “гүйцэтгэгч”/ гэх/ дараахь зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 06 сарын 19-ний өдөр энэхүү гэрээг /цаашид “Гэрээ” гэх/ байгуулав.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, САНХҮҮЖИЛТ

- 3.1 Захиалагч нь “Монгол тарвага сэргээн нутагшуулах” /цаашид “ажил” гэх/ ажлыг 16,500,000 /Арван зургаан сая таван зуун мянган/ төгрөгөөр /цаашид “Гэрээний үнэ” гэх/ гүйцэтгэхээр үнийн санал ирүүлснийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг байгуулав.
- 3.2 Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 3.3 Гэрээний нийт үнэ 16,500,000 төгрөг.
- 3.4 Санхүүжилтийн эх үүсвэр: Байгаль хамгаалал, нөхөн сэргээх, БНАТӨ-ны зардлаас

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

4.1 Гүйцэтгэгч нь “Монгол тарвага сэргээн нутагшуулах” /marmot sibirica/ ажлыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдөр эхэлж 25 толгой монгол тарвагыг шилжүүлэн нутагшуулах ажлыг гүйцэтгэх 2023 оны 07 дугаар сарын 08-ны дотор гүйцэтгэж дуусган гүйцэтгэлийн акт, материалыг захиалагчдад хүлээлгэн өгнө. Тарвага нутагшуулах ажлыг гүйцэтгэхдээ амьтны жам ёсны эрхийг хүндэтгэн үзэж батлагдсан үр дүнтэй хамгийн сайн арга зүйгээр хийнэ.

ТАВ. ГЭРЭЭНИЙ БҮРДЭЛ ХЭСГҮҮД

Дор дурьдсан бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно /цаашид “Гэрээний баримт бичиг” гэх/ үүнд.

- Ажлын даалгавар /хавсралт 1/

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавьж захирал Д.Батсүрэн, уурхайн дарга Д.Дамдин хариуцан ажиллаа.

Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээнд мэргэжлийн байгууллагаар сургалт зохион байгуулсан мөн жил бүрийн ажилчдын эрүүл мэндийн үзлэгийн дараа хамтран ажиллаж буй Дархан-Уул аймгийн Цээнэ эмнэлгээс ажилчдад зонхилж байсан өвчин эмгэгийн талаар сургалт хийсэн, ажилчдыг хөгжүүлэх идэвхижүүлэх байгууллагын дотоод зохион байгуулалтыг сайжруулах зоригоор Оргил эрдэм ундрах ХХК-тай хамтран тус тус сургалтуудыг зохион байгууллаа. Сургалтын үйл ажиллагааны зардалд нийт 2.500.000 төгрөг зарцуулсан.


Орчны хяналт шинжилгээ

Агаар

Агаарын тухай хууль, Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн шаардлага MNS 4585:2016 баримт бичгийг удирдлага болгон агаарын шинжилгээг хийлгэсэн. Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж азотын давхар исэл NO_2 $200\text{мкг}/\text{м}^3$ байхаас $17\text{ мкг}/\text{м}^3$, хүхэрлэг хий SO_2 $450\text{мкг}/\text{м}^3$ байхаас $5\text{ мкг}/\text{м}^3$, PM_{10} тоосонцор $100\text{ мкг}/\text{м}^3$ байхаас $92\text{ мкг}/\text{м}^3$ $\text{PM}_{2.5}$ тоосонцор $50\text{ мкг}/\text{м}^3$ байхаас $47\text{ мкг}/\text{м}^3$ гэсэн үзүүлэлттэй байна.

Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

1. Овоолгын бүтцийн зүй зохистой төлөвлөлт нь хүчтэй салхи шуурганы үед босох тоосыг тодорхой хэмжээгээр багасгахад нөлөөлсөн.
2. Тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн үйл ажиллагааны үе шатанд замын гадаргуу болон уурхайн орчны тоосжилт их болдог газруудыг усалгааны машинаар тогтмол услаж байсан.
3. Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх зааварчилгааг тогтмол өгч мөрдүүлж, хурдны хязгаар тогтоож ажилласан.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ

Дархан сум, 5 дугаар баг, УЦУОШТ-ийн байр
Утас: 7037-3783, 70374161
E-mail: info@darkhan-uul.name.gov.mn



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ТАЙЛАН

Дугаар он/№ : 2023/1-18
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “ИДЭР ХАЙРХАН” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаа : Ц.Оюунчулуун, Ө.Алтанзул,
БОШЛ-ийн инженер, техникч
Сорьцын тоо, төрөл : 2 цэг, агаарын бохирдлын шинжилгээ
Сорьц авсан огноо : 2023.05.17
Шинжилсэн огноо : 2023.05.18
Хуудасны тоо : 1/2


№	Шинжилгээний аргачлал	Агаарын шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS 4585:2016 1 удаагийн сорьцын ХА	Хэмжилт хийсэн цэг
					20 минутын дундаж агууламж 10501г
1	MNS 0017-2-5-12:2021	Хүхэрлэг хий /SO ₂ /	мкг/м ³	450	5
2	MNS 0017-2-5-11:2021	Азотын давхар исэл /NO ₂ /	мкг/м ³	200	17
3	MNS4048-88	Нийт тоос /20 мин/	мкг/м ³	500	320
24 цагийн дундаж агууламж			Хэмжих нэгж	MNS 4585:2016	10502г
4	MNS4048-88	Нийт тоос /TSP/	мкг/м ³	150	135
		PM10 тоосонцор	мкг/м ³	100	92
		PM2.5 тоосонцор	мкг/м ³	50	47

Товчилсон үг: ХА-хүлцэх агууламж
Сорьцын код: 10501г – Бутлуурын орчин
10502г – Оффис орчин

Тайлбар:

- Тухайн сорьц авах, хэмжилт хийх хугацааны цаг агаарын нөхцөл: Агаарын чийгшил 24%, агаарын температур 17.0 градус дулаан, салхи барууны баруун өмнөөс 3м/с хурдтай байсан.
- Агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос, PM10, PM2.5 тоосонцрын агууламж агаарын чанарын MNS 4585-2016 стандартын ХА-аас давсан бохирдолгүй байна.

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:
БОШЛ-ИЙН АГААРЫН ТЕХНИКЧ
ХЯНАСАН:
БОШЛ-ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
БАТАЛГААЖУУЛСАН:
УОШХ-ИЙН ДАРГА



Ө.АЛТАНЗУЛ
Э.САЙНЗАЯА
М.АЛИМАА

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна

030000035

Ус

Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2008, Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээдхэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2005, Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи, түвшинд тавих үндсэн шаардлага MNS 4288:1995, Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам Байгаль орчны сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд, Эрүүл мэндийн сайдын 1995 оны 167/335/A/171 тоот тушаалын 2-р хавсралт зэрэг баримт бичгүүдийг удирдлага болгон Усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээ (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар, Cl, SO₄, NO₂, NO₃, CO₃, HCO₃) Ахуйн хаягдал усны ерөнхий химийн шинжилгээ, бактерлогийн шинжилгээг (рН, ЕС, TDS, нийт шүлтлэг, хатуулгын хэмжээ, рН, цахилгаан дамжуулах чанар) өгсөн.

Ус, усан орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

1. Гадаргын болон гүний усанд хамгаалалтын бүс тогтоож хамгаалалтын бүсэд мөрдөх журмыг чанд сахин ажилласан.
2. Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж ахуйн хатуу хаягдлаа ялган хаяж ачиулсан.



ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ
/Central inspection laboratory/

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-хороо,
Чингүнцавын гудамж Утас: 70180075

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН
СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС**
/ Test result of accredited laboratory /



TL 092
MNS ISO 17025

Захиалагчийн нэр / Customer name /: “Идэр хайрхан” ХХК

Шинжилгээний тодорхойлолт <i>/Analysis type/</i>	Дээжний дугаар <i>/Test number/</i>	Дээжний хаяг, байршил <i>/Sample location/</i>	Уст цэгийн төрөл <i>/Type of water/</i>	
Цэвэр усны хими	№ 1024	Дархан, Хонгор сум, Гүний худаг	Гүний худаг	49°26'07.1" 106°02'31.4"

Дээжний хэмжээ <i>/Quantity of sample/</i>	Дээж хүлээн авсан огноо <i>/Receiving date/</i>	Шинжилсэн огноо <i>/Analyzing date/</i>	Хэвлэсэн огноо <i>/Printed date/</i>	Техникийн шаардлага <i>/Technical requirements/</i>
2.0л/ 2.0л	2023.07.31	2023.07.31-08.01	2023.08.01	MNS 0900:2018

№	Үзүүлэлт <i>/Parameters/</i>	Шинжлэх аргын стандарт <i>/Test method/</i>	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ <i>/Technical specification/</i>	Үр дүн <i>/ Test result/</i>
1	pH-Усны орчин <i>/Hydrogen ions/</i>	MNS ISO 10523-2001	6.5-8.5	7.57
2	Цахилгаан дамжуулах чанар, мСм/см <i>/Electrical conductivity/</i>	MNS ISO 7888:1999	<1.0	1.73
3	Карбонат, (CO ³⁻) мг/л <i>/Carbonate ion, mg/L</i>	MNS ISO 9963-1:2005	-	0.00
4	Гидрокарбонат, (HCO ₃ ⁻) мг/л <i>/Hydrocarbon ion, mg/L</i>	MNS ISO 9963-1:2005	-	298.90
5	Ерөнхий хатуулаг, мг-экв/л <i>/Total hardness, mg-eq/L</i>	MNS ISO 6059:2005	<7.0	12.00
6	Кальци, (Ca ²⁺) мг/л <i>/Calcium ion, mg/L</i>	MNS 1097:1970	<100.0	120.20
7	Магни, (Mg ²⁺) мг/л <i>/Magnesium ion, mg/</i>	MNS 1097:1970	<30.0	131.30
8	Хлорид, (Cl ⁻) мг/л <i>/Chloride ion, mg/L</i>	MNS ISO 9297:2005	<350.0	166.62
9	Хуурай үлдэгдэл, мг/л <i>/TDS, mg/L</i>	MNS 4423:1997	<1000.0	1163.00
10	Сульфат, (SO ₄ ²⁻) мг/л <i>/Sulfate ion, mg/L</i>	MNS 6271:2011	<500.0	255.83
11	Нитрат, (NO ₃ ⁻) мг/л <i>/Nitrate ion, mg/L</i>	MNS ISO 7890-3:2001	<50.0	87.10
12	Нитрит, (NO ₂ ⁻) мг/л <i>/Nitrite ion, mg/L</i>	MNS 4431-2005	<1.0	0.00
13	Аммони, (NH ₄ ⁺) мг/л <i>/Ammonia ion, mg/L</i>	MNS 1097:1970	<1.5	0.29
14	Төмөр, (Fe ³⁺) мг/л <i>/Ferrium ion, mg/L</i>	MNS 4430:2005	<0.3	0.02
15	Натри +Кали, (Na ⁺ , K ⁺) <i>/Sodium+Potassium ion, mg/L</i>	MNS 1097:1970	<200	99.68

Шинжилгээ гүйцэтгэсэн /Test performed by/:

Химич /Chemist/

Ө.Энхбаясгалан /Enkhbayasgalan. U/

Хянасан /Approved/:

Лабораторийн эрхлэгч /Head of laboratory/

Д.Мөнхзул /Munkhzul.D MSc/

Хуудас/ page: 1/1

Сорилтын дүнгийн хуудас нь тухайн сорьцонд хамаарна. /The test result report is applicable to the sample/
Сорилтын лабораторийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлахыг хориглоно. /It is prohibited to reproduce the results without laboratory authorization/

Хөрс

MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл , MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох, MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам, MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх баримт бичгийг удирдлага болгон Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцих кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери тодорхойлуулсан шинжилгээг өгсөн.

Хөрс, ургамал, газарт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

1. Ил уурхай болон газар эвдэх бусад үйл ажиллагаануудыг эхлүүлэхээс өмнө шимт хөрсийг 0.2 – 0.3м зузаантайгаар хуулж авна.
2. Уурхайн хуулж авсан өнгөн хөрсийг овоолго үүсгэлгүй Автозам засварын ажилд ачиулсан.
3. Ашигласан тос маслыг эргэх зуухны тосолгоонд хэрэглэж хаягдалгүй болгосон.



**“GREEN LAB” LLC
ХӨРС, УСНЫ ЛАБОРАТОРИ
СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС**



Дээж ирсэн огноо: 2023.06.22-29
Шинжилгээ хийлгэж буй байгууллага, хувь хүн: “Дорнын байгаль” ХХК
Холбоо барих дугаар: 91113625
Дээж авсан газар: Дархан-Уул аймаг Хонгор сум “Идэр Хайрхан” ХХК

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн / MNS3310:1991/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн см	pH	Давс, %	ЦДЧ	CaCO ₃ %	Ялзмаг %	Шингээгдсэн сууриуд, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
									Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	23/3905	Дээж-1	0-10	8.32	0.06	0.116	0.00	0.60	28.8	1.2	23.0	52
2	23/3906		10-20	8.33	0.05	0.101	0.00	1.66	24.4	1.8	2.1	42
3	23/3907		20-30	8.35	0.04	0.088	0.00	1.19	26.4	2.0	1.2	42

Хөрсний механик бүрэлдэхүүн /MNS 6824:2020/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.06	0.06-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	
1	23/3905	Дээж-1	0-10	1.0	74.5	12.4	3.1	3.7	5.2	12.0
2	23/3906		10-20	1.0	75.8	11.0	4.6	4.3	3.3	12.2
3	23/3907		20-30	0.8	76.8	7.0	5.7	7.5	2.1	15.4

Хөрсний хүнд металл /MNS ISO 11466:2007/

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель	Cd /Кадми	Pb /Хар тугалга	Cu /Зэс	Zn /Цайр	Cr /Хром
1	23/3905	Дээж-1	0-10	15.3	-	6.5	12.8	38.4	19.2
Шавранцар хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ				100.0	1.5	70.0	80.0	150.0	100.0
Элсэнцэр хөрсний зөвшөөрөгдөх дээд хэмжээ				60.0	1.0	50.0	60.0	100.0	60.0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

Хөрсний эрүүл ахуй / MNS 63416:2012, MNS 5367:2004, MNS 6341:2012/

№	Лаб №	Дээжний нэр	Нянгийн тоо	Гэдэсний савханцарын титр (E.Coli)		Анаэробын титр (Cl.perfringens)	
			Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
1	23/3905	Дээж-1	2.7*10 ⁴	1.0	Цэвэр	<0.1	Цэвэр

Жич: Шинжилгээний хариу нь зөвхөн тухайн цэгийн дээжинд хамаарах ба хувилан олшруулахыг хориглоно

ШИНЖИЛГЭЭ ГҮЙЦЭТГЭСЭН:

Шинжээч:
Шинжээч:

Г. Гэрэлтуяа/
С. Мягмардаш/

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

Лабораторийн эрхлэгч

Г.Ганчимэг /M.Sc /

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 6-р хороо, Нөт Капитал байр 10 давхар 02 тоот
Утас/Факс : 72702020, 88950626 E-mail: landownermongolia@gmail.com

**Байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөний
нэгдсэн төсвийн биелэлт**

№	Зардлын утга	Төсөвлөсөн төг	Зарцуулсан	Зарцуулагдаагүй
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	777.000	777.000	
2	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлын зардал	250.000	250.000	
3	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	250.000	250.000	
4	Ургамал болон амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	400.000	400.000	
5	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	600.000	600.000	
6	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	1.400.000	2.510.000	
7	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	0	0	
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	889.200	1.817.970	
9	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	350.000	1.250.000	
Нийт зардлын дүн гүйцэтгэлээр		4.916.200	7.854.970	

Манай компани 2023 оны нөхөн сэргээлт, байгаль хамгаалах ажил, хяналт шинжилгээний хөтөлбөртөө нийт **4.916.200** төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр **7.854.970** төгрөг зарцуулсан буюу 159,7%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс байгалийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын зардалыг тухайн жилийн байгаль орчны газраас өгөх байсан чиглэл тодорхойгүй байсан тул бид өөрсдийн зардлаар санхүүжүүлэхээр 3.000.000 төгрөг төсөвлөөд байсан. Энэхүү ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас Хонгор сумын нутагт 25 толгой Монгол тарвагыг “Амьтны эрх хамгаалах нийгэмлэг” мэргэжлийн байгууллагатай хамтран нутагшуулах ажлыг 2023 оны 07 дугаар сарын 04-ны өдөр зохион байгуулж манай байгууллагын зүгээс 6.420.000 төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож 2.458.100 төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтанд зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан.

Хонгор сумын ЗДТГ-аас Нөхөн сэргээлтийн хүлээн авсан акт авсан, мөн Байгаль орчны чиглэлээр хамтран ажиллах гэрээний тайланг 100% гүйцэтгэлтэйгээр дүгнүүлсэн.

Менежментийн төлөвлөгөөний биелэлт:

“Идэр Хайрхан” ХХК – ийн уурхайн 2023 оны Орчны хяналт шинжилгээний ажлыг 6, 10-р саруудад хийж гүйцэтгүүлсэн. Тус орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ус, агаарын тоосжилт, агаарын бохирдол, хөрсний шинжилгээ хийсэн. Хөрс, агаарын шинжилгээг Дархан-Уул аймгийн “Цаг уур, орчны шинжилгээний газар байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори”, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа хамтын ажиллагааны төв-д хяналтаар дахин ус, хөрсний шинжилгээ хийлгэсэн. Орчны агаарын шинжилгээг агаарын тоосжилтыг хэмждэг DustTrak DRX нэртэй багажаар, агаарын бохирдолыг MX-6 IBRID багажаар хэмжсэн.



Зураг 3. Агаарын бохирдол хэмжсэн MX IBRID багаж



Зураг 4. Агаар дахь тоосжилтыг хэмжсэн Dust Trak DRX багаж

Ил уурхай дахь орчны агаарын тоосжилтын төлөв байдал дундаж утгаар PM_{2.5} 0.062мг/м³ байгаа нь стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 0.8 дахин бага, PM₁₀ 0.1225 байгаа нь стандартад заасан хэмжээнээс бага байсан.

Дүгнэлт

Манай компани нь үйл ажиллагаа нь тогтворжсон байнгийн үйл ажиллагаатай, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заагдсан төлөвлөгөөт ажил үүргээ цаг тухай бүр хийж хэвшсэн, орон нутаг болоод иргэддээ нэр хүндтэй уурхайн нэг юм.

“Цохио толгой 2” шохойн чулууны орд нь 2023 онд ордоос 22.5мян.м³ хөрс хуулж, 18.0мян.тн шохойн чулуу олборлон, 19.8мян.м³ дайрга үйлдвэрлэн борлуулсан байна.

Манай компани нь “Цохио толгой – 2” уурхайд үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 2023 оны эцсээр уурхайн олборлолт, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нийт 7.9га талбайн гадаргуу өртөгдөж байна. Эндээс 0.5 га нь тухайн онд нэмж эвдрэлд орсон байна. Тус онд уурхайн үйл ажиллагаа хэвийн явагдаж багахан хэмжээний хөрс хуулж, шохойн чулуу болон дайвар бүтээгдэхүүнээр дайрга үйлдвэрлэсэн. Өрөмдлөг тэсэлгээний ажилд нийт **141 сая** төгрөгний зардал гарсан.

2023 онд 0.5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдэж дүйцүүлэн хамгаалах зардалд 1га газарт техникийн нөхөн сэргээлт хийж 3,0 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 6,421,5 мян.төгрөг зарцуулсан, 1га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж 5 төрлийн 343 ширхэг мод тарьж гүйцэтгэлээр 2,510,0 мян.төгрөг тус тус зарцуулсан байна. Мөн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх тусгай дансанд 2.458.100 төгрөгийг удирдах байгууллагаас өгөгдсөн хугацаанд байршуулсан.

2023 оны нөхөн сэргээлт, байгаль хамгаалах ажил, хяналт шинжилгээний хөтөлбөртөө нийт **4.916.200** төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр **7.854.970** төгрөг зарцуулсан байна.